

АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

Агро ойн аж ахуй байгуулах

Тендер шалгаруулалтын дугаар:

ОЙГ/20240101026

Улаанбаатар хот
2024 он

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс анgid байх
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл
13. Тендерийн иж бүрдэл
14. Тендерийн жишиг маягтууд
15. Хувилбарт санал
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг
17. Чадавхын болон туршлагын шаардлага
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт
22. Тендерийн валют
23. Тендер хүчинтэй байх хугацаа
24. Тендерийн баталгаа

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх
29. Тендерийг үнэлэх
30. Арифметик алдааг запруулах
31. Давуу эрх олгох
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох
34. Тендерийг эрэмбэлэх
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

36. Мэдэгдэл хүргүүлэх
37. Гүйцэтгэлийн баталгаа
38. Урьдчилгаа төлбөр
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан

3. Худалдан авах ажиллагааны цахим систем

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

13. Тендерийн иж бүрдэл

14. Тендерийн жишиг маягтууд

15. Хувилбарт санал

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

- 16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.
- 16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.2.2. гадаадын иргэн, харьялалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
- 17. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.
- 17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өргтийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендериийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендериийн үнэ” гэж үзнэ.

21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өргтийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

22. Тендерийн валют

23. Тендер хүчинтэй байх хугацаа

бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийт тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.** 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

- | | |
|--|--|
| <p>30. Арифметик алдааг залруулах</p> <p>31. Давуу эрх олгох</p> <p>32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</p> <p>33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох</p> <p>34. Тендерийг эрэмбэлэх</p> <p>35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах</p> | <p>29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.</p> <p>29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.</p> <p>30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.</p> <p>30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.</p> <p>31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.</p> <p>31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.</p> <p>31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.</p> <p>32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.</p> <p>33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.</p> <p>33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.</p> <p>33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.</p> <p>34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.</p> <p>35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.</p> <p>35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.</p> <p>35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.</p> |
|--|--|

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- | | |
|---|--|
| <p>36. Шийдвэр хүргүүлэх</p> <p>37. Гүйцэтгэлийн баталгаа</p> | <p>36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.</p> <p>37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.</p> <p>37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.</p> |
|---|--|

- 38. Урьдчилгаа төлбөр**
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
 - 38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
 - 38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
 - 39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-НЫ
ХОЛБОГОДОХ
ЗААЛТ

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ТШЗ 1.1 Захиалагч: **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР**

ТШЗ 1.1 Тендер шалгаруулалтын нэр: **АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ АЖИЛ**

ТШЗ 1.1 Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: **ОИГ/20240101026**

ТШЗ 1.2 Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

- **БАГЦ №1. ГОВЬ АЛТАЙ АЙМГИЙН БИГЭР СУМ**
- **БАГЦ №2. ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМ**
- **БАГЦ №3 ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН СУМ**
- **БАГЦ №5 ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН ОВОО СУМ**
- **БАГЦ №6. ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМ**

ТШЗ 1.3 Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “**ҮГҮЙ**”

ТШЗ 2.1 Санхүүжилтийн эх үүсвэр нь: **УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ**

ТШЗ 2.1 Нийт төсөвт өртөг: **1,642,500,000 /нэг тэрбум зургаан зуун дөчин хоёр сая таван зуун мянган/ төгрөг**

- **БАГЦ №1. 547,500,000.00 /таван зуун дөчин долоон сая таван зуун мянга/**
- **БАГЦ №2. 438,000,000.00 /дөрвөн зуун гучин найман сая/**
- **БАГЦ №3. 54,750,000.00 /тавин дөрвөн сая долоон зуун тавин мянга/**
- **БАГЦ №5. 54,750,000.00 /тавин дөрвөн сая долоон зуун тавин мянга/**
- **БАГЦ №6. 547,500,000.00 /таван зуун дөчин долоон сая таван зуун мянга/**

Б. АГУУЛГА

ТШЗ 9.1 Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:

Хүлээн авагч: **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ “ОЙН ГАЗАР”**

Хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХЭЛТЭС, 301 ТООТ**

Утасны дугаар: **7711-1180**

Цахим шуудангийн хаяг: **info@forestry.gov.mn**

ТШЗ 10.1 Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “**ҮГҮЙ**”

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

ТШЗ 12.1 Тендер шалгаруулалтын хэл: **МОНГОЛ ХЭЛ.**

ТШЗ 15.1 Хувилбарт санал ирүүлэхийг: **“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”**

ТШЗ 16.1.2 Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: **“ШААРДАНА”**

1. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСНААС ХОЙШ ХУГАЦААНД ЦАХИМ СИСТЕМЭЭС АВСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН БОЛОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТЫГ ЦАХИМ СИСТЕМИЙН ХОЛБОГОДОХ ТАЛБАРААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ ТУС ТУС**

ИРҮҮЛНЭ.

2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ӨР, ТӨЛБӨРГҮЙ ТАЛААРХ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЛАВЛАГААГ ЦАХИМ СИСТЕМЭЭС АВЧ, ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ ЦАХИМ СИСТЕМЭЭР ХОЛБОГДОХ ТАЛБАРААР ИРҮҮЛНЭ.
3. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭТГЭЭДИЙН ИТГЭМЖЛЭЛ ИРҮҮЛНЭ.
4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ТОДОРХОЙЛОЛТ, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ИРҮҮЛНЭ.

- Тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архибын лавлагaa авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лаёлгагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлттээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг
- цахим хэлбэрээр ирүүлнэ.
- Жич: Дээр 2 лавлагагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцуна уу.

5. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨЛТИЙГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ (E-MONGOLIA) СИСТЕМЭЭС ШАЛГНАА.
6. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГҮҮЛСЭН ГАЗАР, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХАЯГИЙГ ТОДОРХОЙЛСОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХЭЭС ХИЙСЭН ХУУЛБАР, ЭСВЭЛ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ БУСАД БАРИМТ БИЧИГ

Туслан гүйцэтгэгч, түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “ШААРДАНА”

- ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТУС БҮР ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙХ БӨГӨӨД ХОЛБОГДОХ МЭДЭГДЭЛ, БАРИМТ БИЧИЙГ ЭНЭ ХУУЛИЙН 7.2, 7.3-Т ЗААСНААР ИРҮҮЛНЭ.
- ТЕНДЕРТ ИРҮҮЛЭХ ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ НЬ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА. САНГИЙН САЙДЫН 2023 ОНЫ А/248 ДУГААР ТУШААЛААР БАТЛАГДСАН “ЦАХИМ СИСТЕМЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЖУРАМ”-ЫН 2.3.1-Д ЗААСНААР ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭГ ЦАХИМ СИСТЕМЭЭР БАТАЛГААЖУУЛСАН БАЙНА. МӨН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ХУВИЙГ ТЕНДЕРИЙН ХАМТ ИРҮҮЛЭХ.
- ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭНД ТҮНШЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮН БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮД ТУС БУРИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮНИЙН ДҮН, ХУВИЙГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙНА.
- ТҮНШЛЭЛИЙН АЛЬ НЭГ БОЛОН БҮХ ГИШҮҮНИЙ НЭРИЙН ӨМНӨӨС ҮҮРЭГ ХҮЛЭЭХ, ЗААВАРЧИЛГАА ХҮЛЭЭН АВАХ, ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХЭД ТЭДГЭЭРИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ НЭГ ГИШҮҮН ТОМИЛОХ.
- НИЙТ ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ДОТОР ТӨЛБӨРИЙГ ЗӨВХӨН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮНТЭЙ ТООЦОХЫГ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГЭЭР ЗОХИЦУУЛСАН БАЙХ.
- ТҮНШЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮН ТШЗ-НЫ 18, 19-Д ЧАДАВХЫН БОЛОН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН 40-ААС ДЭЭШ ХУВИЙГ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТУС БҮР 25 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИЙГ ХАНГАСАН БАЙНА. ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛООГҮЙ БОЛ ЕРӨНХИЙ ШААРДЛАГАД НИЙЦЭХГҮЙ ГЭЖ ҮЗНЭ.

Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 20 хүртэл хувь байна. Туслан гүйцэтгэгчтэй холбоотойгоор дараах материалыг ирүүлэх шаардлагатай.

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ ЦАХИМ СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН БАЙНА. ГЭРЭЭНД ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ, ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮН, ХУГАЦААГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙНА. ТУСЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ ХУУЛИЙН 6.4-Т ЗААСНЫГ ЗӨРЧСӨН БОЛ ЗАХИАЛАГЧ ТУХАЙН ТУСЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИД ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙГ ТЕНДЕР ХЯНАН ҮЗЭХЭД ХАРГАЛЗАН ҮЗЭХГҮЙ.
- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА.
- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ НЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАРЫГ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАГҮЙ БӨГӨӨД УГ МЭДЭЭЛЛИЙГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ”-ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА.
- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛООГҮЙ БОЛ ЕРӨНХИЙ ШААРДЛАГАД НИЙЦЭХГҮЙ ГЭЖ ҮЗНЭ.

ТШЗ 18.1 Санхүүгийн чадавхын шаардлага: “ШААРДАХГҮЙ”

- Борлуулалтын орлогын хэмжээ: **2021, 2022, 2023 ОНЫ АЛЬ НЭГ ЖИЛД НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ХЭМЖЭЭ НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙН 10 ХУВИАС БАГАГҮЙ БАЙХ.**
- Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **ТЕНДЕРТ САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ҮНИЙН ДҮНГИЙН 30%-ААС БАГАГҮЙ БАЙХ.**
- Байгууллагын дансны улдэгдэл* /Харилцагч банкны тодорхойлолт, тендер нээхээс 7 хоногийн өмнө харилцагч банкнаас авсан байх/
- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. Тухайн зээл нь судлагдсан байх шаардлагатай. Тухайн тендерийн ажилтай холбоотой ямар нэгэн нөхцөл шаардлага тавихгүйгээр олгох зээлийг үнэлгээнд авч үзэх бөгөөд бусад тохиолдолд тус шаардлагыг хангаагүй гэж үзнэ.
- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсээт заасан үнэт цааснууд. /Хувь хүн эзэмшиж буй үнэт цаас, хадгаламж хамаарахгүй/
- Өр, төлбөртэй холбогдо шаардлага: “**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ** ХУУЛИЙН 4.1.5-Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БҮХИЙ “**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ**”-ЫГ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГҮЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО. (“**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ**”-ЫГ WWW.SAINSCORE.MN, WWW.BURENSCORE.MN ХАЯГААР ХАНДАН АВНА.
- Бусад шаардлага: **СҮҮЛИЙН 2 ЖИЛ БУЮУ 2022, 2023 ОНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛНЭ.**

ТШЗ 18.2 Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:

- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН МЭДЭЭЛЛИЙГ**

- САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН WWW.E-BALANCE.MOF.GOV.MN МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ДЭХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАА.
- ТУРГЭН ХӨРВӨХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НИЙТ ДҮНГ ДАРААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН АЛЬ НЭГЭЭР ЭСВЭЛ НИЙЛБЭРЭЭР ТОДОРХОЙЛНО. ҮҮНД:

- Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл;
- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойполт;
- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.
- ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА 2022, 2023 ОН;
- ХАРИЛЦАГЧ БАНКНЫ МЭДЭГДЭЛ;
- “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ” хуулийн 4.1.5-Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БҮХИЙ “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГУЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.
- СҮҮЛИЙН ХОЁР ХҮРТЭЛ ЖИЛИЙН ХУГАЦААНД ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ХУУЛИЙН ДАГУУ ГАРГАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН;
- СҮҮЛИЙН ХОЁР ХҮРТЭЛ ЖИЛИЙН ХУГАЦААНД ОРОЛЦОГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛСЭН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН МЭДЭЭЛЭЛ.
- САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙЛГЭХ ҮҮРЭГТЭЙ ОРОЛЦОГЧИЙН ХУВЬД САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ

ТШЗ 19.1

Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “ШААРДАНА”

Ажил гүйцэтгэх хүний нөөц: “ШААРДАНА”

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Үндсэн /Гэрээт/	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
1	Ерөнхий инженер	1	Ойн инженер, Ой зүйч, Ойн аж ахуйн инженер	Үндсэн	8 жилээс дээш
2	Ойжуулагч	1	Ойн аж ахуйн инженер ойн техникич, ойжуулагч	Гэрээт	5 жилээс дээш
3	Жолооч	2	Мэргэшсэн	Гэрээт	5 жилээс дээш
4	Түр ажилтан	20	-	Гэрээт	-

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН САНАЛ БОЛГОСОН НИЙТ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТӨЛСӨН БОЛОХЫГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАХ ҮЗНЭ. ХЭРЭВ ШААРДЛАГА ХАНГААГУЙ БОЛ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕР ГЭЖ ҮЗНЭ.
- АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙГ УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛСАН ТАНИЛЦУУЛГА ИРҮҮЛНЭ.
- ҮНДСЭН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙГ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"-ЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАА. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн

ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ уу. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>

- ГАДААДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨН БОЛ ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ИРҮҮЛНЭ.
- ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧДАД ОЛГОСОН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ, ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ГЭРЧИЛГЭЭГ ТУС ТУС НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭН ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛД ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.
- ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БОЛОХЫГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ”-ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. СҮҮЛИЙН 6 САР ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БАЙХ ШААРДЛАГАТАЙ. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТNUUDЫН БИЧИГ БАРИМТЫГ ДУТУУ ИРҮҮЛЭХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ДЭЭР ДУРДСАН ХУГАЦААНД ТӨЛӨГДӨӨГҮЙ ТОХИОЛДОЛД УГ ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:
“ШААРДАНА”

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Тоо хэмжээ	Хүчин чадал	Өөрийн / Түрээс
1	Трактор, дагалдах агрегатын хамт	1	80-аас дээш морины хүчтэй, 70 см хүртэл хагалах өгөгдөл анжис	Түрээс
2	Нүх ухагч	10	-	Өөрийн
3	Ачааны автомашин	1	5 тонн-оос дээш даацтай	Түрээс
4	Хүн тээврийн автомашин	1	8-10 хүн нэгэн зэрэг тээвэрлэх боломжтой	Түрээс

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМУУДЫН ЖАГСААЛТЫГ V БҮЛГИЙН МАЯГТ-3 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛНЭ. ТҮРЭЭССЭЭР ХЭРЭГЛЭХ БОЛ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ НОТАРИАТААР БАТЛУУЛЖ, ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭГ ХАВСАРГАНА. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖИЙН ХУВЬД ФОТО ЗУРГИЙГ ИРҮҮЛНЭ.

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “ШААРДАНА”

СҮҮЛИЙН З ЖИЛ БУЮУ 2021, 2022, 2023 ОНУУДЫН АЛЬ НЭГ ЖИЛД ДООД ТАЛ НЬ НЭГ УДАА ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧЭР АЖИЛЛАСАН БАЙНА. ЭНЭ ШАЛГУУРЫГ ДООР ДУРДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР ХЯНАН ҮЗНЭ. /Ижил төстэй ажил гэдэгт байгалийн сэргэн ургалтад туслах, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн, төрөл бүрийн хамгаалалтын ойн зурvas байгуулсан, үр түүх байнгын болон түр талбай тусгаарлах арчлах, татмын ойжуулалт, булаг хөв цөөрмийг эргийг хамгаалах зурvas байгуулсан ажил гүйцэтгэж байсан туршлагыг голлон авч үзнэ./ ҮҮНД:

- БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 10 ХУВИАС БАГАГҮЙ ҮНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ.
- ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГ ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ТУХАЙН БАГЦАД ЗААГДСАН АЖЛЫН НИЙТ ТАЛБАЙН ХЭМЖЭЭНИЙ ЗО БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬ БҮХИЙ ТАЛБАЙД ДҮЙЦЭХҮЙЦ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ.
- ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭ, АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ

ЗАХИАЛАГЧИЙН ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ.

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:
“ШААРДАНА”

- ТЕНДЕРТ САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН 30-ААС ДЭЭШ ХУВЬ НЬ ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН ДУУСААГҮЙ АЖИЛД ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАНА.

№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг, төг	Дууссан, дуусах хугацаа	Ажиллаж буй боловсон хүчиний нэр, хугацаа
1					
2					

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: **“ШААРДАНА”**

- ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,
- ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД БҮРЭН ХАРИУЦАН, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭН, АЖИЛЛАХ ТАЛААР БАТАЛСАН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ,
- ЗАХИАЛАГЧ ХАРИЛЦАГЧ БАНК, НИЙГМИЙН ДААТГАЛ, ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГУУДААС ТОДОРХОЙЛОЛТ ХҮСЭХЭД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛГҮЙ ТУХАЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН АЛБАН МЭДЭГДЭЛ,
- АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ЧАНАРЫН ЗӨРЧИЛ, ГОЛОГДОЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ТҮҮНИЙГ ЗАСАХ, ЗАЛРУУЛАХ ТУХАЙ ШААРДЛАГА ӨГӨХӨД ҮЛ МАРГАЛДАХ ЖУРМААР БИЕЛҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,
- ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ДАГУУ ТООЦСОН ТӨСӨВ ИРҮҮЛНЭ. УГ ТӨСӨВТ ХОЛБОГОДХ ТАТВАР ХУРААМЖ, ДААТГАЛЫГ БҮРЭН ХАМРУУЛСАН БАЙНА.
- ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ, ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ БАТАЛГААЖУУЛЖ ИРҮҮЛЭХ,
- САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ БАЙГУУЛСАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, НОТАРИАТААР БАТАЛГААЖУУЛАН ИРҮҮЛЭХ,
- ТЕНДЕРТ ШАЛГАРСАН ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ЗАХИАЛАГЧААС ТОГТООСОН ҮЕ ШАТНЫ ХУВААРТЬ ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ ЧАНАРЫН Өндөр ТҮВШИНД ТУХАЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭН ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭН Өгөх БАТАЛГААГ БИЧГЭЭР ГАРГАЖ ИРҮҮЛНЭ.
- СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН АЛЬ НЭГ ЖИЛД ХИЙХ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХИЙСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ. ГЭРЭЭ БОЛОН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТЫН ХУУЛБАРЫГ ХАВСАРГАНА. ДУУСААГҮЙ ГЭРЭЭНИЙ ХУВЬД ТАЙЛБАР ХИЙСЭН БАЙНА.
- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ӨӨРӨӨ ҮЙЛДВЭРЛЭЭГҮЙ ТАРЬЦ, СУУЛГАЦЫГ АШИГЛАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ САНАЛ ИРҮҮЛЖ БУЙ ТОХИОЛДОЛД ТАРЬЦ, СУУЛГАЦ НИЙЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БОЛОХЫГ НОТЛОХ НИЙЛҮҮЛЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ИРҮҮЛНЭ.
- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ОЛОН БАГЦАД ТЕНДЕР ИРҮҮЛЭХ БОЛОН ӨӨР ИЖИЛ ТӨРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БОЛ ЗӨВХӨН ТУХАЙН БАГЦАД АЖИЛЛУУЛАХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫГ САНАЛ БОЛГОСОН ТЕНДЕР ИРҮҮЛНЭ. (ХЭРЭВ ЗАХИАЛАГЧИЙН ЗАРЛАСАН БУСАД ТЕНДЕРҮҮДЭД САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР,

ТЕХНИКИЙН АЖИЛТАН ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ
ҮНДЭСЛЭЛ БОЛНО.)

- ТШЗ 19.2** Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: “ШААРДАНА”

Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлнэ. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ҮНДСЭН АЖИЛТАН, ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ АЖИЛЛАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ СИСТЕМ ДЭХ V БҮЛЭГТ ЗААСАН МАЯГТААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ САНАЛ БОЛГОНО. ЦАХИМ СИСТЕМЭЭР САНАЛ БОЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД ХЯНАН ҮЗЭХГҮЙ. ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ХӨТӨЧ ЦЭСИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА ХЭСГЭЭС ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦАНА УУ.
- АЖИЛТНЫ СУРГУУЛЬ ТӨГССӨН ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАГҮЙ, ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ, СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАНА. (ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ /E-MONGOLIA/-Д АЖИЛТНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ДИПЛОМЫН МЭДЭЭЛЭЛ БАЙРШСАН ЭСЭХИЙГ УРЬДЧИЛАН ШАЛГАХ ШААРДЛАГАТАЙГ АНХААРНА УУ,) ХЭРЭВ САНАЛ БОЛГОЖ БУЙ АЖИЛТАН НЬ ГАДААД УЛСАД СУРГУУЛЬ ТӨГССӨН БОЛ ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ОРЧУУЛГЫН ХАМТ ИРҮҮЛНЭ.
- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ҮНДСЭН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. БУСАД АЖИЛТНЫ ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭГ ЗӨВХӨН ТУХАЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗОРИУУЛАН БАЙГУУЛСАН БАЙНА.
- МЭРГЭШСЭН, ЗӨВЛӨХ ЗЭРЭГТЭЙ АЖИЛТАН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛТНЫ ХУЧИН ТӨГӨЛДӨР МЭРГЭЖЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ ТЕНДЕРТ ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.
- НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 3.1.4-Т ЗААСАН НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫГ САНАЛ БОЛГОХ ТОХИОЛДОЛД МӨН ХУУЛИЙН 18.5.3-Т ЗААСАН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, ЭРХ БУХИЙ БАЙГУУЛЛАГЫН БИЧГЭЭР ӨГСӨН ЗӨВШӨӨРЛИЙГ ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.
- ТУХАЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ДЭЭРХ САНАЛ БОЛГОСОН АЖИЛТНААС ӨӨР АЖИЛТНААР АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛСЭН ТОХИОЛДОЛД ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ БУХИЙ ТЕНДЕР ГЭЖ ҮЗЭН ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД ХАМРУУЛАХ НӨХЦӨЛ БОЛОХЫГ АНХААРНА УУ.

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН БОЛОН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ АШИГЛАХ МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЦАХИМ СИСТЕМ ДЭХ V БҮЛЭГТ ЗААСАН МАЯГТААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ САНАЛ БОЛГОНО. ЦАХИМ СИСТЕМЭЭР САНАЛ БОЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД ХЯНАН ҮЗЭХГҮЙ. ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ХӨТӨЧ ЦЭСИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА ХЭСГЭЭС ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦАНА УУ.
- МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ НЬ ИРГЭНИЙ ХУУЛИЙН 318 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦСЭН, МАШИН МЕХАНИЗМЫН УЛСЫН ДУГААР, АШИГЛАХ ХУГАЦАА, ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР БУСАД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ.

Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 4, 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. Үүнд:

- ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГЭЭР ТООЦУУЛАХ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН ХУВЬД: АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭ, ГЭРЭЭ ДУГНЭСЭН АКТ, ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН ДҮГНЭЛТ, АКТЫГ ИРҮҮЛНЭ.
- ХҮЧИН ЧАДАЛ, ОЙЖУУЛСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭГЭЭР ТООЦУУЛАХ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН ХУВЬД: АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭ, ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН ДҮГНЭЛТ, АКТЫГ ИРҮҮЛНЭ.

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ӨӨРИЙН БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ТУС ТУС ИРҮҮЛНЭ.
- ЗАХИАЛАГЧ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦ, АЖИЛТАН, МАШИН МЕХАНИЗМЫН ТАЛААР МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙГ САНГААС ХЯНАН ҮЗНЭ.

ТШЗ 19.3 Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “ШААРДАНА”

“ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫН 4.1.6 ДАХЬ ЗААЛТАД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА. ҮҮНД:

- ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ (МОД ҮРЖҮҮЛЭХ, ОЙЖУУЛАХ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ)

ТШЗ 21.6 Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад:

“ТОХИРУУЛАХГҮЙ ТОГТМОЛ БАЙНА”

ТШЗ 24.1 Тендерийн баталгааны дүн:

Багц №1: 2,737,500.00 /хоёр сая долоон зуун гучин долоон мянга таван зуун/ төгрөг;

Багц №2: 2,190,000.00 /хоёр сая нэг зуун ерэн мянган/ төгрөг;

Багц №6: 2,737,500.00 /хоёр сая долоон зуун гучин долоон мянга таван зуун/ төгрөг;

Тендерийн баталгааг материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерийн баталгаа гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна. Захиалагч тендерийн баталгааг хуулийн 28.1.1-д зааснаар “хамгийн сайн тендер ирүүлсэн” оролцогчид гэрээ байгуулсны дараа цахим системээр хүчингүй болгоно. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн A/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.3.3 дахь хэсэгт заасны дагуу цахим системээр дамжуулан тендерийн баталгааг ирүүлнэ.


Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа: **ТЕНДЕР НЭЭСЭН ӨДРӨӨС ХОЙШ АЖЛЫН 30 ХОНОГ ДУУСТАЛ ХҮЧИНТЭЙ БАЙНА.**

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5 Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:

- ТЕНДЕРТ ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ТОВЧОО;
- АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУВААРЬ.

- ТШЗ 26.1** Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:
- Огноо: **2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр**
Цаг: **10 цаг 00 минут**
- ТШЗ 26.2** Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.
- Огноо: **2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр**
Цаг: **10 цаг 20 минут**
- Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг:
- МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БЯНГХААНЫ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II
БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 3
ДАВХАР, 301 ТООТ**
- Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ**
- ТШЗ 31.1** Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:
- **ДАВУУ ЭРХ ТООЦУУЛАХ ТУХАЙ ХҮСЭЛТ;**
 - **ДАВУУ ЭРХ ТООЦУУЛАХ НӨХЦӨЛ ХАНГАЖ БУЙ ТАЛААР НОТЛОХ
БАРИМТ ИРҮҮЛНЭ.**
- (Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу давуу эрх олгоно.)
- ТШЗ 32.1** Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “**ҮГҮЙ**”
- Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
- ТШЗ 37.1** Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “**ТИЙМ**”
- Багц №3, Багц №5-т гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй
ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН З ХУВИАР ТООЦОЖ ИРҮҮЛНЭ.**
- Ё. БУСАД**
- ТШЗ 38.1** Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “**ҮГҮЙ**”
- АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ТӨЛБӨР ТООЦНО.**



АГРО ОЙН АХУЙ БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР
/ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/

2024 оны 4-р сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн A/10 дугаар тушаалаар батлагдсан "Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө"-д тусгагдсан агро ойн аж ахуй байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хамрах хүрээ	Агро ойн аж ахуй байгуулах талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав.
3	Гүйцэтгэх ажил	Агро ойн аж ахуйн байгуулах ажлын хүрээнд доор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: Бэлтгэл ажил Хамгаалалтын хашаа барих Хамгаалалтын ойн зурvas байгуулах Худаг гаргах Усны нөөц сав байрлуулах Усалгааны систем суурилуулах
	Төсөвт өртөг	2,190,000,000.00 (хоёр тэрбум нэг зуун ерэн сая) төгрөг
4	Талбайн хэмжээ	200 га талбай
5	Техникийн шаардлага	Агро ойн аж ахуйн байгуулах ажлыг гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгац, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг мөрдөж ажиллана.
6	Модны төрөл	Тухай орчин тохирсон зүйл.
7	Хугацаа	Хаврын тарилт 2024.05.10 Намрын нөхөн тарилт 2024.09.27 Дараах жилийн арчилгаа, нөхөн тарилт 2025.05.10 Тендерийн баримт бичигт заагдсан үе шатны ажлын хуваарь болон, гүйцэтгэгчээс ирүүлсэн тодотгосон үе шатны ажлын хуваарьтай уялдан өөрчлөгдж болно.
8	Ажлын үе шат	- Бэлтгэл ажил - Хамгаалалтын хашаа барих - Хамгаалалтын ойн зурvas байгуулах - Худаг гаргах - Усны нөөц сав байрлуулах - Усалгааны систем суурилуулах - Талбайг хүлээлгэн өгөх

8		<ul style="list-style-type: none"> - Зөрчил гологдол арилгах - Тайлан боловсруулах - Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх
		<p>Бэлтгэл ажил:</p> <ul style="list-style-type: none"> • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах; • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох; • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дарааллын загварыг хавсаргав/ • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцэн сонгох/; • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах • Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана. <p>Агро ойн аж ахуй байгуулах</p> <ul style="list-style-type: none"> • “Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага” MNS 6140:2010 стандартын I,II зэргийн тарьц суулгац, “Навчит төрлийн модны суулгацын Техникийн шаардлага” MNS 6141:2010 стандартын хавсралт паспорттой, “Улиасны суулгац. Ерөнхий шаардлага” MNS 6257:2011 стандартуудад нийцсэн суулгацуудыг ойн зурvas байгуулах ажилд хэрэглэх • Агро ойн аж ахуйн байгуулахаар сонгосон талбайд хашаа барина. Хашааны 2-3 метр тутамд нэг шон байхаар тооцож хашаа барина. • Нийт 50 га талбайн 23 га талбайд хамгаалалтын зурvasын модыг схемийн дагуу 33750 ширхэг тарина. • Багц 3, Багц 4-ын 5 га талбайгаас 3 га талбайд зурvasын модыг схемийн дагуу 3750 ширхэг тарина. • Агро ойн аж ахуйн талбайд 1 ширхэг худаг өрөмдөж гаргах худгийн гүн 120 метр хүртэлх гүнтэй байж болно. • Худгийн барилга 34 м.куб-ээс дээш хэмжээтэй барина. Худгийн барилга угсралт, тохижилтийн ажлын хүрээнд бэлчээрийн худгийн барилга ариун цэвэр, эрүүл ахуй стандартын дагуу гадна талбайд 3x3 метр бетон цутгах, • Усалгааны 20 тонн хэмжээтэй нөөц сав 2 ширхгийг суурь хийж

		<p>дээр нь байрлуулна.</p> <ul style="list-style-type: none"> • Багц 3, Багц 4 тус бүрийн 5 га талбайд 3 тонн хэмжээтэй нөөцийн сав 1 ширхэг суурь хийж дээр нь байрлуулна. • Багц 3, Багц 4 тус бүрийн 5 га талбайн • Дуслын усалгааны систем байрлуулна. Усалгааны систем нь (Хүчин чадалд тохирсон насос, фильтр, хаалт, төв шугам, крант, дуслын систем, төгсгөлийн хаалт, шилжүүлэгч, төгсгөгч) гэх мэт иж бүрдэлтэй 75000 метр хүртэл урттай байх • Шоо дөрвөлжин нүхтэй 1.4 метрээс багагүй өндөртэй хагас ган 5 мм-ийн голчтой тэмрөөр хийсэн торон хашаа барих • Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах арга. Ерөнхий шаардлага” MNS 6258-1:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэнэ. • Шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийх • Хамгаалалтын зурvas байгуулах 23 га талбайд эгнээ хооронд 3-3,5 метр, мод, сөөг хооронд 2-2,5 метр байхаар тооцон 1 га талбайд 1250 ширхээс доошгүй стандартын шаардлага хангасан чанартай суулгацаар тарилтыг хийх, • Эгнээ хоорондын мод тарих 60 см гүн, 80 см өргөн шан татаж, шуудуу хооронд байгаа модыг зик зак хэлбэртэй байхаар таригдана. • Ойн зурvas дундуур 5 га талбайд 300 м*100м харьцаатай нийт 27 га сул талбай үлдээж жимс жимсгэнийн мод, сөөг, хүнсний ногоо, үр тариа суулгахаар төлөвлөх • Уулын налуу болон жалгын ховилоор хашаан доогуур жижиг мэрэгч амьтан болон мал орохоос сэргийлэх жижиг тор татах • Усалгаа хийх автомашин талбайд нэвтрэхэд зориулж 3-3,5 метрийн өргөнтэй хаалга гаргасан байна. • Тарьсан суулгацыг арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах, тогтмол усалгааны ажил гүйцэтгэх <p>Технологийн шийдэл</p> <ul style="list-style-type: none"> • Салхины зонхилох чиглэлийн дагуу перпендикуляр үндсэн ойн зурvasыг байгуулах, • Салхины дагуу чиглэлд туслах ойн зурвастай байх, • Талбайг тэгш үр бүтээмжтэй хуваах хэлбэрээр дэд туслах ойн зурvasыг байгуулах • Талбай дундуур чөлөөтэй зорчих зориулалт бүхий машины зам 5 м байхаар тооцох, • Дэд ойн зурvas, дэд туслах ойн зурvas хооронд 300 м байх, • Үндсэн ойн зурвасаас дэд туслах ойн зурvas хооронд 100 м байна. • Говь хээрийн бүсийн цөлжилтэд өртсөн талбайд шуудуунд мод тарихын өмнө шуудууны гүнд баяжуулсан бууц, хар шорооны холимог бүхий 20 см хөрсийг хийж өгөх <p>Талбайг хүлээлгэн өгөх</p> <p>Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулсан талбайг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Ойн зурvas байгуулсан талбайг тухайн аймаг, суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Амьдралтын хувийг тогтооходоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03</p>
--	--	---

дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.

Ойн зурвасын талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишиг талбайн хэмжээ /м ² /
1-5	5	200
6-10	4	400
11-20	3	400
21-ээс дээш	2	400

Ойн зурvas байгуулсан ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна.

Зөрчил, гологдол арилгах.

- Суулгасан суулгац нь 60-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө.
- Суулгасан суулгац нь 25-50 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.
- Суулгасан суулгац нь 24,9 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.

Тайлан боловсруулах.

Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

a/ “Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан”;

b/ Ойн ажилтны гарын авлагад заасан загвараар 1:50000-ны масштабтай Ойн зурvas байгуулах ажил явуулсан талбайн схем ландшафтын зураг;

v/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.

a. “Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан”-д:

“Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулсан ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага

	<p>хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойн зурвасын ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана.</p> <p>б. “Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажил явуулсан талбайн зураг”-т: Талбайн хилийн солбицол, дугаар, талбайн хэмжээ, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насын бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>в. Ойн зурвасын тус бүрийн эгнээг Үндсэн зурvas, Үндсэн туслах зурvas, Дэд зурvas, Туслах зурvas, Дэд туслах зурвасаар ялгаж эгнээ бүрт тарьсан модны тоог хүснэгтээр бичих,</p> <p>г. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана.</p> <p>Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.</p> <p>Зураг боловсруулалтын ажлыг Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтын тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ. Ойн зурvas байгуулах ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.</p> <p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <p>“Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулсан ажлын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хоёр хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p>
--	--

**АГРО ОЙН АЖ АХУЙН ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ
ШААРДЛАГУУД (MNS, ISO9001:2015, UCS)**

Агро ойн аж ахуйн хамгаалалтын ойн зурvas байгуулах ажлын гүйцэтгэлд гүйцэтгэгч байгууллага нь дараах стандартуудыг мөрдөж ажиллана.

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа	MNS 4969:2000
2	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо. Шаардлага	MNS OSHAS 18001:2012
3	Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6139:2010
4	Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага”	MNS 6140:2010


5	Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6141:2010
6	Мод үргүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага	MNS 2418:2011
7	Мод үргүүлгийн газар бордоо хэрэглэх	MNS 6252:2011
8	Мод сөөгний үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага	MNS 6253-1:2011
9	Мод сөөгний үр тарих Ерөнхий шаардлага	MNS 6253-2:2011
10	Мод сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага	MNS 6253:2011
11	Мод сөөгний суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага	MNS 6254:2011
12	Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6255:2011
13	Сөөгөнцөрийн суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6256:2011
14	Улиасны суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6257:2011
15	Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага	MNS 6258-1:2011
16	Мод сөөгний суулгац арчлах	MNS 6258-2:2011
17	Улиасны модожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага	MNS 1796:2011
18	Бордоо. Доломитын бордоо Техникийн шаардлага	MNS 6662:2017
19	Сөөгний суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага	MNS 6773:2019
20	Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах	MNS 6774:2019
21	Голтборын төрлийн ургамлыг тарих, арчлах. Техникийн шаардлага	MNS 6863: 2020
22	Мод үргүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац ургуулах Техникийн шаардлага	MNS 6864:2020
23	Навчит модны суулгац, техникийн шаардлага	MNS 6141:2020
24	Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага	MNS 5891:2008
25	Фосфорын бордоо	MNS 4305: 1996
26	Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага 11.1 дэх хэсгийн загвар	UCS 1410B:2022
27	Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага	MNS 6088:2010

Агро ойн аж ахуйд таригдах боломжтой мод, сөөгүүд

Мод, сөөг ургамлын монгол, латин нэрс					
1	Цагаан модот заг <i>Haloxylon ammodendron</i>	14	Элдэв навчит улиас/Тоорой <i>Populus diversifolia</i>	27	Говийн харгана <i>Caragana gobica</i>
2	Олонцээгт сухай <i>Tamarix ramosissima</i>	15	Цагаан бургас <i>Salix Ledebouriana</i>	28	Үхэр харгана <i>Caragana microphylla</i>
3	Муркрофтын жигд <i>Elaeagnus moorcroftii</i>	16	Мөнгөлөг улиас <i>Populus alba</i>	29	Бор харгана <i>Caragana bungei</i>
4	Нарийннавчит жигд <i>Elaeagnus angustifolia</i>	17	Улиангар <i>Populus tremula</i>	30	Шар хуайс <i>Caragana arborescens</i>
5	Бариулт бүйлс <i>Amygdalus pedunculata</i>	18	Сибирь улиас <i>Populus sibirica</i>	31	Тэмээн харгана <i>Caragana spinosa</i>
6	Монгол бүйлс <i>Amygdalus mongolica</i>	19	Татар агч <i>Acer tatarica</i>	32	Хонхот харгана <i>Halimodendron halodendron</i>
7	Улаан түлээ <i>Calligonum mongolicum</i>	20	Яшилдуу чацаргана <i>Hippophae rhamnoides</i>	33	Тэхийн шээг <i>Ribes diacantha</i>
8	Тарваган хайлас <i>Ulmus pumila</i>	21	Азийн мойл <i>Padus asiatica</i>	34	Нохой шээрэн/хотир <i>Zygophyllum xanthoxylon</i>
9	Том үрт хайлас <i>Ulmus macrocarpa</i>	22	Час-улаан долоогоно <i>Crataegus sanguine</i>	35	Сибирь хармаг <i>Nitraria sibirica</i>
10	Монгол зорлог <i>Calligonum mongolicum</i>	23	Сибирь гүйлс <i>Armenia sibirica</i>	36	Усан хармаг <i>Nitraria sphaerocarpa</i>
11	Улаан модот яшил	24	Монгол чаргай	37	Роборовскийн хармаг

	<i>Rhamnus erythroxylon</i>		<i>Cotoneaster mongolica</i>		<i>Nitraria Roborovskii</i>
12	Морин зээргэнэ <i>Ephedra equisetina</i>	25	Сийрэг сарнай <i>Rosa laxa</i>	38	Арзгар-үрт хармаг <i>Nitraria sphaeocarpa</i>
13	Өрөл <i>Malus baccata</i>	26	Цагаан яргай <i>Cornus alba</i>	39	Монгол мөнх харгана <i>Ammopiptanthus mongolicus</i>

Агро ойн аж ахуйн ерөнхий схем



Ногоон хэрэм төслийн Төв аймгийн Лүн суманд хэрэгжүүлсэн агро ойн аж ахуйн талбайн хамгаалалтын ойн зурвасын схемын жишиг

- 80 см гүн, 1 метр өргөн шан татна.
- Үндсэн зурвасын гадна талын 16 эгнээ хоорондоо 2,5 - 3 метр
- Туслах зурvas 8 эгнээ, хоорондоо 2,5 -3 метр
- Дэд зурvas 8 эгнээ, хоорондоо 2,5-3 метр
- Дэд туслах зурvas 4-5 эгнээ, хоорондоо 2,5- 3 метр
- Эгнээ хооронд мод, сөөгийг сөөлжилдсөн (зик зак) хэлбэрээр тарина.

Үе шатны ажлын хуваарь

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	-	2024-10-20-ны дотор
2	Агро ойн аж ахуй байгуулах	50 га	2024-10-25-ны дотор
3	Талбайг хүлээлгэн өгөх	50 га	2024-10-30-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	50 га	2024-11-01-ний дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	-	2024-11-5-ны дотор
6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	-	2024-11-15-ны дотор
7	Дараа жилийн арчилгаа, хамгаалалт		2025-12-01-ны дотор

Ажил гүйцэтгэх байршил /багцын мэдээлэл/

№	Багцын дугаар	Багцын нэр	Талбайн хэмжээ, га	1 га талбайд таригдах модны модны тоо	1 га талбайн зардлын норматив, төгрөгөөр	27 га, 3 га тус бүрт Нийт таригдах модны тоо	Төсөвт өртөг, төг	Талбайн байршил, координат Decimal Degrees	Талбайн байршил, ОЗБ-ын материал
1	Багц 1	Говь-Алтай аймгийн Бигэр суманд агро ойн аж ахуй байгуулах ажил	50	1250	10,950,000.00	33,750	547,500,000.00	45.686469°, 97.388758° 45.688233°, 97.406650° 45.683228°, 97.389875° 45.685169°, 97.407572°	Бигэр сум
2	Багц 2	Дундговь аймгийн Сайнцагаан суманд агро ойн аж ахуй байгуулах ажил	40	1250	10,950,000.00	27,000	438,000,000.00	45.819961°, 106.314189° 45.819056°, 106.319368° 45.810052°, 106.312579° 45.809416°, 106.309218° 45.820246°, 106.311377°	Сумын төвийн орх хаалганы орчим
3	Багц 3	Дундговь аймгийн Дэрэн суманд агро ойн аж ахуй байгуулах ажил	5	1250	10,950,000.00	3,750	54,750,000.00		
4	Багц 5	Дундговь аймгийн Сайхан-Овоо суманд агро ойн аж ахуй байгуулах ажил	5	1250	10,950,000.00	3,750	54,750,000.00		
5	Багц 6	Хөвсгөл аймгийн Мөрөн суманд агро ойн аж ахуй байгуулах ажил	50	1250	10,950,000.00	33,750	547,500,000.00		
ДҮН		150	-	-	102,000	1,642,500,000.00			

Хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга
Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Ганзориг


Б.Өсөхбаяр

Боловсруулсан:


Агро ой, хамгаалалтын ойн зурvas
хариуцсан мэргэжилтэн:

А.Алтанбагана

Багц № 1 Говь-Алтай аймгийн Бигэр суманд агро ойн аж ахуй байгуулах ажил



Багц № 2 Дундговь аймгийн Сайнцагаан суманд агро ойн аж ахуй байгуулах ажил



IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн санаалаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана. Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: “**Ашиглахгүй**”
2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “**Ашиглахгүй**”
3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “**Ашиглахгүй**”
4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “**Ашиглахгүй**”

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хулэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлж болно.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

- Маягт 1. Тендер илгээх
- Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл
- Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл
- Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл
- Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл
- Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл
- Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1. Тендер илгээх

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалгачийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо] өдрийн хугацаанд хүчинтэй байна.
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалгачийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн догондлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн догондлой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь

Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | |
|-----------------------------------|--|
| Захиалагчийн нийтлэг үүрэг | 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнэ.
2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнэ.
2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч | 2.4. Захиалагчийг төлөөлнөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |
| Талбайд нэвтрэх зөвшөөрөл | |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | |
|------------------------------------|---|
| Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнэ.
3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнэ.
3.3. Ажил гүйцэтгэхэд шаардлагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч | |

Техникийн болон ажлын талбайн өгөгдөл	3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
Ажлын талбайн харуул хамгаалалт	3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна. 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажилласад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
Хог, хаягдал ба нөхөн сэргээлт	3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана. 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.
Археологийн болон бусад олдвор	3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна. 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
Аюулгүй байдал	3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна. 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ. 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана. 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална. 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилана. 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна. 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна. 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх	4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ. 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ. 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна. 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд
-------------------	---

Хугацаа сунгах	<p>Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон; 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал; 4.5.3. Захиалагч хугацаандaa төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй; 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн. <p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бурийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p>
Ажлын явцын тайлан	<p>ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ</p>

Гэрээний үнэ	<p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p>
Урьдчилгаа төлбөр	<p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>
Төлбөрийн нөхцөл	<p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнэ.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн</p>

тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

Урьдчилгаа төлбөрийн баталгаа

- 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

- 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
- 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
- 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
- 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
- 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

- 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

- 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

- 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнэ.

- 6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.

- 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.

- 6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.

- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.

- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.

- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

Чанарын баталгаа

Баталгаат хугацаа

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

**Бусдад учруулсан
хохирлыг арилгах**

**Захиалагчийн хүлээх
эрсдэл**

Даатгал

- 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
 - 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
 - 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
 - 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
 - 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

**Доголдлыг илрүүлэх,
арилгах**

- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж

- болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- Далд доголдол**
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Зураг төслийн доголдол**
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- Захиалагч гэрээг цуцлах**
- 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
 - 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
 - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах**
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сэргээр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам**
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоо шаардлагагүй, нэмэлт хугацаа

- Гэрээг цуцалсны дараах төлбөр**
- 9.7. тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
 - 9.8. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэнсээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
 - 9.9. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
 - 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
 - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
 - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
 - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
 - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл**
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
 - 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
 - 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
 - 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
 - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
 - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
 - 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
 - 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
 - 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх**
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
 - 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
 - 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
 - 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд

	хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл	<p>10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.</p> <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p>
Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал	<p>10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p>
Оюуны өмчийн эрх зөрчих	<p>10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.</p> <p>10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p>
Алданги	<p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p>
Маргаан шийдвэрлэх	<p>10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.</p> <p>10.26. Маргааныг зөвшилцэж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 4.1. Ажил эхлэх хугацаа: **ГЭРЭЭ БАЙГУУЛСНААС ХОЙШ 7 ХОНОГ**
- ГЕН 4.2. Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: **ГЭРЭЭ БАЙГУУЛСНААС ХОЙШ 5 ХОНОГ**
- ГЕН 4.9. Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: **2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НИЙ ӨДӨР**
- ГЕН 5.2. Унийн тохируулга “**ХИЙХГҮЙ**”
- ГЕН 5.4. Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “**ҮГҮЙ**”
- ГЕН 5.5. Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: “**БАЙХГҮЙ**”
- ГЕН 5.6. Төлбөр төлөх хугацаа: “**АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ТООЦНО**”
- ГЕН 6.1. Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: “**ҮГҮЙ**”
- ГЕН 6.7. Чанарын баталгаа: “**ШААРДАНА**”
Чанарын баталгааны хэмжээ: “**ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 5 ХУВЬ**”
- ГЕН 6.13. Баталгаат хугацаа: **2 ЖИЛ**
- ГЕН 7.5. Даатгал: “**ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ДАГУУ ГАРАХ ДААТГАЛЫН ЗАРДЛЫГ ГҮЙЦЭТГЭГЧ БҮРЭН ХАРИУЦНА**”
- ГЕН 10.21. Захиалагчийн төлөх алдангийн хувь:
Алдангийн хувь: “**ХОНОГ ТУТАМД ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 0.5 ХУВЬ**”
- ГЕН 10.22. Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:
Алдангийн хувь: “**ХОНОГ ТУТАМД ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 0.5 ХУВЬ**”

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнэ. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА